



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/10

Онги

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 461 дүгээр тогтоол, Дундговь аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/15 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан улсын нөөцөөс хямдруулсан үнээр өвс, тэжээлийн нөөцийг бэлтгэсүгэй.

2. Өвс, тэжээлийн зардалд шаардагдах 18,843,750(Арван найман сая найман зуун дөчин гурван мянга долоон зуун тавин) төгрөгийг Мал хамгаалах сангийн төсвөөс гарган зарцуулахыг нягтлан бодогч (Э.Наранцэцэг)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМАРСАНАА